Монгол Улсын Их Хурлын 2021 оны 58 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:*** *Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

| | |
|---|---|
| **Нэр дэвшигчийн товч танилцуулга** | |
| **1** | **Эцэг/эхийн нэр:**Сүхбаатар<br>**Нэр:** Эрдэнэбат<br>**Хүйс:** Эрэгтэй<br>**Нэр дэвшүүлсэн байгууллага:** Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| **2** | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**<br>Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаалыг бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн **даатгуулагчийг** төлөөлсөн гишүүн |

**Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:**
Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэг Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

**1/**2022.03.22-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг баталсан. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос тус холбооны ерөнхийлөгч **Сүхбаатарын Эрдэнэбатыг** нэр дэвшүүлж, Байнгын хорооноос баталсан загварын дагуу материалыг ирүүлсэн болно.

**2/**2023.03.15-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” тогтоолыг баталж, 2023.04.10-ны өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн **Цагаанхүүгийн Идэрбатыг** томилсон.

**3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:**
-Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу УИХ-ын цахим хуудаст байршуулсан
-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, news.zindaa.mn, Ubn.mn, Times.mn, tovch.mn,

zarig.mn, MGL радио, Монголын үндэсний олон нийтийн радио 23 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

-Мэдээллийн дагуу 4 оролцогч нэр дэвшигчээс асуулт асуухаар, 5 оролцогч үг, санал хэлэхээр бүртгүүлснийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар эрэмбэлэн бүртгэж, баталгаажуулсан.

-2023.04.04-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр **Лувсангийн Мөнх-Эрдэнийг** хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 саналаар томилсон.

-Шинжээч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125.10-т заасан эрхийн хүрээнд Байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч нэр дэвшигчидтэй 2023.04.06-ний өдөр Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд уулзалтыг зохион байгуулж ярилцлага авсан (нэг нэр дэвшигч эрүүл мэндийн шалтгааны улмаас цахимаар оролцсон) болно. Нэр дэвшигчдийн ирүүлсэн анкет, нэр дэвших үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлын мэдээлэл болон ярилцлагын дүнд үндэслэн 2023.04.07-ны өдөр Хараат бус шинжээчийн дүгнэлтийг Байнгын хороонд ирүүлснийг ажлын алба Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн болно.

**4/**Байнгын хорооны ажлын албанаас 2023.04.07-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.2-т заасны дагуу сонсголд оролцогчдод сонсголын дэгийг урьдчилан танилцуулсан.

**5/**2023.04.10-ны өдрийн 14:00 цагт Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс дээш гишүүд хүрэлцэн ирснээр ирц бүрдэж Нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат даргалан эхлүүлсэн. Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн, С.Чинзориг нарын гишүүд оролцсон.

**6/**Нэр дэвшигч С.Эрдэнэбат нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ дүгнэлтээ танилцуулсан.

**7/**Танилцуулга, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, С.Ганбаатар нар асуулт асууж, хариулт авсан.

**Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа:** Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ тогтмол төлөөд тухайн жилдээ үйлчилгээ аваагүй иргэд төлсөн шимтгэлээ буцаан авах боломжтой эсэх болон Эрүүл мэндийн даатгалын өнөөгийн тогтолцоог хамгийн зөв тогтолцоо болгохын тулд юу хийх шаардлагатай талаар асуулт асуув.

**Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар:** Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг шамшигдуулсан албан тушаалтнуудад ямар хариуцлага хүлээлгэх болон сангийн хөрөнгийг хэрхэн хамгаалах, мөн өнгөрсөн 30 жилд ЭМД төлсөн иргэдээс танай байгууллага дээр холбоотой хэдэн гомдол гаргасан, ирүүлсэн гомдлуудыг

хэрхэн шийдвэрлэсэн судалгаа байгаа эсэх талаар, даатгуулагчдад тайлангаа хэрхэн гаргах талаар асуулт асуулаа.

**8/**Улсын Их Хурлын гишүүдийг асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан асуулт асуухаар бүртгүүлсэн оролцогч нар дараах дарааллын дагуу нэр дэвшигчээс асуулт асуусан.

**Р.Эрдэнэбат** – ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** – МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** – иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн

**9/**Нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан үг хэлэхээр бүртгүүлсэн оролцогч нар саналаа хэлсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлэх санал гараагүй болно.

**Р.Эрдэнэбат** – ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** – МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** – иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн
**Б.Булганчимэг** - Өвөрхангай, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, Эмнэлгийн удирдлагын зөвлөх

**10/**Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Цагаанхүүгийн Идэрбат хааж үг хэлсэн.

**Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ц.Идэрбат:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу 2 дахь удаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшигчдийг 3 үе шаттайгаар хэлэлцдэг тогтолцоо руу орж байна. Хоёр дахь удаа хөндлөнгийн хараат бус шинжээч дүгнэлт хийж, нэр дэвшигч, төлөөллийн байгууллагууд оролцоод байр сууриа илэрхийллээ. Хөндлөнгийн шинжээч нэр дэвшигчдийн талаар өөрийнхөө дүгнэлтийг тал талаас нь хийж сонсголд танилцуулаад, нэр дэвшигч нар өөрсдийн байр сууриа илэрхийллээ. Байнгын хороо дүгнэлтээ хийгээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

| | |
|---|---|
| **3** | **Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь**<br>Томилгооны сонсгол зохион байгуулах журмын 3.1-д зааснаар нэр дэвшигчийг санал болгох, нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, **сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан бичих** үе шат тус бүрийг Байнгын хороо хэрхэн зохион байгуулсан тухай болон сонсголыг Нийтийн сонсголын тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар нэгтгэн дүгнэж бичнэ. Дүгнэлтийнхээ гол үндэслэлийг товч бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Нэр дэвшигчийн сонсголыг явуулах үе шат, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны |

| | |
|---|---|
| | дэгийн тухай хуулийн 123-126 дугаар зүйлийг баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2023.04.10-ны өдрийн 14:00 цагт зохион байгууллаа.<br><br>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2023.04.12-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргалаа. |
| **4** | **Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.** |
| | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд тус холбооны ерөнхийлөгч **С.Эрдэнэбатыг** дэвшүүлсэн бөгөөд:<br><br>**1/Нэр дэвшигч Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр** томилогдвол Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, даатгуулагчийн эрх ашгийг байж болох түвшинд хамгаалах, болзошгүй эрсдэлээс хамгаалах чадавхыг сайжруулахад анхаарах болно.<br>Манай улс ЭМД-ын эв санааны үзэл баримтлалд суурилсан тогтолцоотой бөгөөд цаашид хосолсон шудрага тогтолцоотой байх хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал төр хариуцаж байгаа ахмад, хүүхдийн даатгал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний даатгалын төлбөр нь маш бага хэмжээтэй байгаа нь даатгал ачааллаа дийлж чарахгүй байдалд хүргэж байна. Мөн хөрөнгийн удирдлагын байдалд гаргасан алдаануудыг засахад анхаарч ажиллана.<br><br>Удирдлагын тогтолцоо даатгалын зөвлөл бараг хаалттай байгаа нь асуудал дагуулсаар ирсэн. Тухайлбал гаргасан шийдвэрүүдээ олон нийтэд танилцуулдаггүй, санал зөвлөмж авдаггүй, төлөөлөх эрхгүй хүмүүс томилогдсон зэрэг нь дутагдалтай байна. Мөн даатгалын тусламж үйлчилгээний чанар өртөг нөхцөл зэрэгт бодит үнэлгээ дүгнэлт өгөх шаардлагатай байна. Тухайлбал хэвтэн эмчлүүлэгчдийн ор хоног, эм тарианы чанар, эмчилгээний өртөг, чанарын үнэлгээг даатгуулагчдийн төлөөлөл байнга хийж байх шаардлагатай байна. Нөгөө талаар гүйцэтгэлийн санхүүжилтийн хүрээнд үүсч буй аймаг, дүүрэг, сумын өрхийн эмнэлгүүдийн өөрөө өөрийгөө санхуужүүлэх чадавх, бодит боломжид нийцсэн санхүүжилтүүдийг боловсронгуй болгоход анхаарна.<br><br>Хүний нөөцийн асуудал нь даатгалын санхүүжилттэй шууд холбогдож байгаа тул давхар тооцож ажиллах шаардлага байна. Үүнээс болж сайн боловсон хүчин хувийн эмнэлэг, төв эмнэлгүүд рүү шилжих бодит эрсдэлүүд нүүрлэж байна. Энэ нь 1, 2-р шатлалын эмнэлгүүдэд бодит хүний нөөцийн эрсдэл илүү нүүрлэж байгаа нь чанар үйлчилгээ шууд холбогдож байна.<br><br>ЭМДҮЗ аливаа шийдвэр гаргахдаа мэргэжлийн экспертүүдийн санал дүгнэлтийг авч гаргаж байх шаардлагатай.<br><br>Миний бие олон эмч ажилчид, даатгуулагчдын санал хүсэлтийг авч ажиллаж байдаг тул ЭМДҮЗ-ийн зарим шийдвэрүүд бодит байдалд үл нийцсэн |

даатгуулагчдад болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад ихээхэн хүндрэл бэрхшээл үзүүлдэгийг засч сайжруулах шаардлагатай.

-ЭМД- ын сангийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай.

-ЭМД-ын тогтолцоо үйлчилгээг сайжруулахад даатгуулагчдын эрх ашгийг ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүйгээр үр дүнтэй ажиллахаа илэрхийлэв.

**2/Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ:**

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 07 тоот тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагад дүгнэлт өгөхөөр томилогдсоны дагуу нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийж, нэр дэвшигчээс мэдлэг шалгах сорил авч, ярилцлага зохион байгуулсаны үндсэн дээр хараат бус шинжээчийн дүгнэлт гаргалаа.

Дээрх үнэлгээний үр дүнд үндэслэн нэр дэвшигч С.Эрдэнэбат нь ЭМДҮЗ-ийн гишүүнээр ажиллахад мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, ажлын туршлагын хувьд шаардлага хангасан, ашиг сонирхлын ямар нэгэн зөрчилгүй гэсэн дүгнэлтийг өгч байна.

**3/Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч С.Эрдэнэбатыг** хараат бус шинжээчийн дүгнэлт, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд дэмжлээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголоос гаргасан “Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохдоо Үндэсний зөвлөл нь санхүү, эрүүл мэндийн эдийн засгийн нарийн судалгаа, тооцоонд үндэслэн мэргэжлийн шийдвэр гаргадгийг харгалзан Үйлдвэрчний эвлэлд олон жил ажилласан, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл гэхээс илүү нийт даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрүүл мэндийн салбарын эдийн засгийн асуудлаар мэргэшсэн, мэдлэг, ур чадвартай хүнийг дэвшүүлэх” зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

**Сонсголд даргалагч:**

Ц.ИДЭРБАТ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 58 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:** Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

| | |
|---|---|
| **Нэр дэвшигчийн товч танилцуулга** | |
| 1 | **Эцэг/эхийн нэр:**Баасан<br>**Нэр:** Алтанхуяг<br>**Хүйс:** Эрэгтэй<br>**Нэр дэвшүүлсэн байгууллага:** Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| 2 | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**<br>Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаалыг бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн **даатгуулагчийг** төлөөлсөн гишүүн |
| **Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:**<br>Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэг Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.<br><br>**1/**2022.03.22-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг баталсан. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд дарга **Баасангийн Алтанхуягийг** нэр дэвшүүлж, Байнгын хорооноос баталсан загварын дагуу материалыг ирүүлсэн болно.<br><br>**2/**2023.03.15-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” тогтоолыг баталж, 2023.04.10-ны өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн **Цагаанхүүгийн Идэрбатыг** томилсон.<br><br>**3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:**<br>**-**Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу УИХ-ын цахим хуудаст байршуулсан<br>-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, news.zindaa.mn, Ubn.mn, Times.mn, tovch.mn, | |

zarig.mn, MGL радио, Монголын үндэсний олон нийтийн радио 23 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

-Мэдээллийн дагуу 4 оролцогч нэр дэвшигчээс асуулт асуухаар, 5 оролцогч үг, санал хэлэхээр бүртгүүлснийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар эрэмбэлэн бүртгэж, баталгаажуулсан.

-2023.04.04-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр **Лувсангийн Мөнх-Эрдэнийг** хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 саналаар томилсон.

-Шинжээч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125.10-т заасан эрхийн хүрээнд Байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч нэр дэвшигчидтэй 2023.04.06-ний өдөр Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд уулзалтыг зохион байгуулж ярилцлага авсан (нэг нэр дэвшигч эрүүл мэндийн шалтгааны улмаас цахимаар оролцсон) болно. Нэр дэвшигчдийн ирүүлсэн анкет, нэр дэвших үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлын мэдээлэл болон ярилцлагын дүнд үндэслэн 2023.04.07-ны өдөр Хараат бус шинжээчийн дүгнэлтийг Байнгын хороонд ирүүлснийг ажлын алба Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн болно.

**4/**Байнгын хорооны ажлын албанаас 2023.04.07-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.2-т заасны дагуу сонсголд оролцогчдод сонсголын дэгийг урьдчилан танилцуулсан.

**5/**2023.04.10-ны өдрийн 14:30 цагт Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс дээш гишүүд хүрэлцэн ирснээр ирц бүрдэж Нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат даргалан эхлүүлсэн. Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн, С.Чинзориг нарын гишүүд оролцсон.

**6/**Нэр дэвшигч Б.Алтанхуяг нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ дүгнэлтээ танилцуулсан.

**7/**Танилцуулга, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, С.Ганбаатар нар асуулт асууж, хариулт авсан.

**Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа:** Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ тогтмол төлөөд тухайн жилдээ үйлчилгээ аваагүй иргэд төлсөн шимтгэлээ буцаан авах боломжтой эсэх болон Эрүүл мэндийн даатгалын өнөөгийн тогтолцоог хамгийн зөв тогтолцоо болгохын тулд юу хийх шаардлагатай талаар асуулт асуув.

**Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар:** Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг шамшигдуулсан албан тушаалтнуудад ямар хариуцлага хүлээлгэх болон сангийн хөрөнгийг хэрхэн хамгаалах, мөн өнгөрсөн 30 жилд ЭМД төлсөн иргэдээс танай байгууллага дээр холбоотой хэдэн гомдол гаргасан, ирүүлсэн гомдлуудыг

хэрхэн шийдвэрлэсэн судалгаа байгаа эсэх талаар, даатгуулагчдад тайлангаа хэрхэн гаргах талаар асуулт асуув.

**8/**Улсын Их Хурлын гишүүдийг асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан асуулт асуухаар бүртгүүлсэн оролцогч нар дараах дараалын дагуу нэр дэвшигчээс асуулт асуусан.

**Р.Эрдэнэбат** – ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** – МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** – иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн

**9/**Нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан үг хэлэхээр бүртгүүлсэн оролцогч нар саналаа хэлсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлэх санал гараагүй болно.

**Р.Эрдэнэбат** – ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** – МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** – иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн
**Б.Булганчимэг** - Өвөрхангай, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, Эмнэлгийн удирдлагын зөвлөх

**10/**Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Цагаанхүүгийн Идэрбат хааж үг хэлсэн.

**Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ц.Идэрбат:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу анх удаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшигчдийг 3 үе шаттайгаар хэлэлцдэг тогтолцоо руу орж байна. Анх удаа хөндлөнгийн хараат бус шинжээч дүгнэлт хийж, нэр дэвшигч, төлөөллийн байгууллагууд оролцоод байр сууриа илэрхийллээ. Хөндлөнгийн шинжээч нэр дэвшигчдийн талаар өөрийнхөө дүгнэлтийг тал талаас нь хийж сонсголд танилцуулаад, нэр дэвшигч нар өөрсдийн байр сууриа илэрхийллээ. Байнгын хороо дүгнэлтээ хийгээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

| | |
|---|---|
| 3 | **Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь**<br>Томилгооны сонсгол зохион байгуулах журмын 3.1-д зааснаар нэр дэвшигчийг санал болгох, нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, **сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан бичих** үе шат тус бүрийг Байнгын хороо хэрхэн зохион байгуулсан тухай болон сонсголыг Нийтийн сонсголын тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар нэгтгэн дүгнэж бичнэ. Дүгнэлтийнхээ гол үндэслэлийг товч бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^{1}$ дүгээр зүйлийн $14^{1}$.3 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Нэр дэвшигчийн сонсголыг явуулах үе шат, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-126 дугаар зүйлийг баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2023.04.10-ны өдрийн 14:00 цагт зохион байгууллаа. |

| | |
|---|---|
| | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2023.04.12-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргалаа. |
| **4** | **Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.** |
| | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд дарга **Б.Алтанхуягийг** дэвшүүлсэн бөгөөд:<br><br>**Нэр дэвшсэн үндэслэлийн талаар:**<br>Өнөөдрийн монгол улс дах эрүүл мэндийн даатгалын төрөл, албан журмын даатгалын зарчим /Эв санааны нэгдлийн/, шимтгэлийн хувь хэмжээ, түүнийг төлөх журам нь орчин үеийн, олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах бодит шаардлагыг хангаж буй эсэх, түүнд мониторинг хийж, даатгуулагчийн эрүүл мэндэд ирээдүйд учирч болох бүхий л эрсдлийг даатгалын сангийн үйл ажиллагаагаар бүрэн хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, мөн эрүүл мэндийн даатгалын байгууллагуудын тогтолцоо, үйл ажиллагааг орчин үеийн цахим технологид суурилсан өндөр бүтээмж, үр ашигтай, оновчтой системийг нэвтрүүлэх, хамгийн чухал нь нийт даатгуулагчдын төлсөн шимтгэл, мөнгөн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, зарцуулалтад хяналт тавих, даатгуулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хараат бус, бие даасан байдлаар ажиллах зорилгоор нэр дэвшсэн болно.<br><br>ЭМДҮЗ-д сонгогдвол дараах ажлуудыг санаачлан Үндэсний зөвлөлийн хурлаар дэмжүүлэн хийж хэрэгжүүлнэ. Үүнд:<br><br>**Хийх ажлын талаар:**<br>1. Эрүүл мэндийн даатгалын мөнгөн хөрөнгө төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг цахимаар зохион байгуулах талаар эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх,<br>2. Даатгуулагчдыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зайлшгүй авах эрсдэлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгийн чанар хүртээмж, нийт даатгуулагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн цахим болон үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, түүний хэрэгжилтийг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан гүйцэтгүүлэх,<br>3. Даатгалын байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, түргэн шуурхай, үр ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд санал санаачилга, хяналтыг хэрэгжүүлж ажиллах,<br>4. Даатгуулагч өвчилсөн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах зайлшгүй шаардлага бий болсон тохиолдолд олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг монголдоо авах нөхцөлийг бүрдүүлэх, өндөр төлбөртэй, гадаад улс оронд хийгддэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийн эрсдэлийг давхар даатгалд хамруулах, гадаад орон руу явж буй валютын урсгалыг багасгах, |

5. Даатгуулагчдын даатгалын мөнгөн хөрөнгийн захиран зарцуулалтыг хууль тогтоомж, үнэт зүйл, ёс суртахууны үзэл баримтлалуудыг удирдлага болгон шийдвэр гаргаж, зөвлөлийн гишүүдийн хараат бус, бие даасан, хяналтын, үр ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн дүрэм журам боловсруулан, санал гаргаж, батлуулан ажиллах,
6. Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага барагдуулах, орлого зарлагын менежментийг сайжруулах, санхүүгийн үзүүлэлт, үр дүнг сайжруулах талаар олон улсын туршлагад суурилж холбогдох саналыг гарган, хэрэгжүүлж ажиллах

**2/Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ:**

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 07 тоот тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагад дүгнэлт өгөхөөр томилогдсоны дагуу нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийж, нэр дэвшигчээс мэдлэг шалгах сорил авч, ярилцлага зохион байгуулсаны үндсэн дээр хараат бус шинжээчийн дүгнэлт гаргалаа.

Дээрх үнэлгээний үр дүнд үндэслэн нэр дэвшигч Б.Алтанхуяг нь ЭМДҮЗ-ийн гишүүнээр ажиллахад мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, ажлын туршлагын хувьд шаардлага хангасан, ашиг сонирхлын ямар нэгэн зөрчилгүй гэсэн дүгнэлтийг өгч байна.

**3/Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Б.Алтанхуягийг** хараат бус шинжээчийн дүгнэлт, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголоос гаргасан “Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохдоо Үндэсний зөвлөл нь санхүү, эрүүл мэндийн эдийн засгийн нарийн судалгаа, тооцоонд үндэслэн мэргэжлийн шийдвэр гаргадгийг харгалзан Үйлдвэрчний эвлэлд олон жил ажилласан, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл гэхээс илүү нийт даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрүүл мэндийн салбарын эдийн засгийн асуудлаар мэргэшсэн, мэдлэг, ур чадвартай хүнийг дэвшүүлэх” зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

**Сонсгол даргалагч:**

Ц.ИДЭРБАТ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 58 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:*** *Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

| **Нэр дэвшигчийн товч танилцуулга** | |
|---|---|
| **1** | **Эцэг/эхийн нэр:**Түдэв<br>**Нэр:** Баясгалан<br>**Хүйс:** Эрэгтэй<br>**Нэр дэвшүүлсэн байгууллага:** Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| **2** | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**<br>Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаалыг бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн **даатгуулагчийг** төлөөлсөн гишүүн |

**Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:**
Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэг Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

**1/**2022.03.22-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг баталсан. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, ШУ-ны салбарын ҮЭХ-ны дарга **Түдэвийн Баясгаланг** нэр дэвшүүлж, Байнгын хорооноос баталсан загварын дагуу материалыг ирүүлсэн болно.

**2/**2023.03.15-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” тогтоолыг баталж, 2023.04.10-ны өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, **сонсгол** даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн **Цагаанхүүгийн Идэрбатыг** томилсон.

**3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:**
**-**Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу УИХ-ын цахим хуудаст байршуулсан
-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, news.zindaa.mn, Ubn.mn, Times.mn, tovch.mn,

zarig.mn, MGL радио, Монголын үндэсний олон нийтийн радио 23 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

-Мэдээллийн дагуу 4 оролцогч нэр дэвшигчээс асуулт асуухаар, 5 оролцогч үг, санал хэлэхээр бүртгүүлснийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар эрэмбэлэн бүртгэж, баталгаажуулсан.

-2023.04.04-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр **Лувсангийн Мөнх-Эрдэнийг** хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 саналаар томилсон.

-Шинжээч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125.10-т заасан эрхийн хүрээнд Байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч нэр дэвшигчидтэй 2023.04.06-ний өдөр Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд уулзалтыг зохион байгуулж ярилцлага авсан (нэг нэр дэвшигч эрүүл мэндийн шалтгааны улмаас цахимаар оролцсон) болно. Нэр дэвшигчдийн ирүүлсэн анкет, нэр дэвших үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлын мэдээлэл болон ярилцлагын дүнд үндэслэн 2023.04.07-ны өдөр Хараат бус шинжээчийн дүгнэлтийг Байнгын хороонд ирүүлснийг ажлын алба Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн болно.

**4/**Байнгын хорооны ажлын албанаас 2023.04.07-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.2-т заасны дагуу сонсголд оролцогчдод сонсголын дэгийг урьдчилан танилцуулсан.

**5/**2023.04.10-ны өдрийн 14:00 цагт Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс дээш гишүүд хүрэлцэн ирснээр ирц бүрдэж Нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат даргалан эхлүүлсэн. Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн, С.Чинзориг нарын гишүүд оролцсон.

**6/**Нэр дэвшигч Т.Баясгалан нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ дүгнэлтээ танилцуулсан.

**7/**Танилцуулга, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, С.Ганбаатар нар асуулт асууж, хариулт авсан.

**Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа:** Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ тогтмол төлөөд тухайн жилдээ үйлчилгээ аваагүй иргэд төлсөн шимтгэлээ буцаан авах боломжтой эсэх болон Эрүүл мэндийн даатгалын өнөөгийн тогтолцоог хамгийн зөв тогтолцоо болгохын тулд юу хийх шаардлагатай талаар асуулт асуув.

**Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар:** Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг шамшигдуулсан албан тушаалтнуудад ямар хариуцлага хүлээлгэх болон сангийн хөрөнгийг хэрхэн хамгаалах, мөн өнгөрсөн 30 жилд ЭМД төлсөн иргэдээс танай байгууллага дээр холбоотой хэдэн гомдол гаргасан, ирүүлсэн гомдлуудыг

хэрхэн шийдвэрлэсэн судалгаа байгаа эсэх талаар, даатгуулагчдад тайлангаа хэрхэн гаргах талаар асуулт асуув.

**8/**Улсын Их Хурлын гишүүдийг асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан асуулт асуухаар бүртгүүлсэн оролцогч нар дараах дараалын дагуу нэр дэвшигчээс асуулт асуусан.

**Р.Эрдэнэбат -** ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** - МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** - Иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх "Жаргал" нийгэмлэгийн тэргүүн

**9/**Нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан үг хэлэхээр бүртгүүлсэн оролцогч нар саналаа хэлсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлэх санал гараагүй болно.

**Р.Эрдэнэбат** - ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** - МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** - Иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх "Жаргал" нийгэмлэгийн тэргүүн
**Б.Булганчимэг -** Өвөрхангай, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, Эмнэлгийн удирдлагын зөвлөх

**10/**Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Цагаанхүүгийн Идэрбат хааж үг хэлсэн.

**Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ц.Идэрбат:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу анх удаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшигчдийг 3 үе шаттайгаар хэлэлцдэг тогтолцоо руу орж байна. Анх удаа хөндлөнгийн хараат бус шинжээч дүгнэлт хийж, нэр дэвшигч, төлөөллийн байгууллагууд оролцоод байр сууриа илэрхийллээ. Хөндлөнгийн шинжээч нэр дэвшигчдийн талаар өөрийнхөө дүгнэлтийг тал талаас нь хийж сонсголд танилцуулаад, нэр дэвшигч нар өөрсдийн байр сууриа илэрхийллээ. Байнгын хороо дүгнэлтээ хийгээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

| | |
|---|---|
| 3 | **Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь**<br>Томилгооны сонсгол зохион байгуулах журмын 3.1-д зааснаар нэр дэвшигчийг санал болгох, нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, **сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан бичих** үе шат тус бүрийг Байнгын хороо хэрхэн зохион байгуулсан тухай болон сонсголыг Нийтийн сонсголын тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар нэгтгэн дүгнэж бичнэ. Дүгнэлтийнхээ гол үндэслэлийг товч бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Нэр дэвшигчийн сонсголыг явуулах үе шат, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-126 дугаар зүйлийг баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2023.04.10-ны өдрийн 14:00 цагт зохион байгууллаа. |

| | |
|---|---|
| | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2023.04.12-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргалаа. |
| 4 | **Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.** |
| | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, ШУ-ны салбарын ҮЭХ-ны дарга **Т.Баясгаланг** нэр дэвшүүлсэн бөгөөд:<br><br>**1/Нэр дэвшигч Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилогдвол** Нийт хөдөлмөр эрхэлж байгаа ажилчдыг төлөөлөн энэхүү даатгалын үр өгөөж, ашиг шимийг тэдэнд илүү ээлтэй байдлаар шийдвэрлүүлэхэд орших бөгөөд ЭМД-ын шимтгэл төлснөөр иргэд хэвтэн эмчлүүлэх, амбулаторийн тусламж, үйлчилгээ, оношлогоо шинжилгээ, уламжлалт эмчилгээ, нөхөн сэргээх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээ, зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт, өндөр өртөгт мэс заслын тусламж үйлчилгээ, хорт хавдрын хими туяаны эмчилгээ зэрэг үйлчилгээнүүдийг авах эрхтэй ч даатгуулагчид эдгээр үйлчилгээний талаар бүрэн мэдээлэлгүйн улмаас төлбөр төлөн эмчлүүлэх, өндөр үнэтэй эм, тариаг хөнгөлөлтгүй үнээр худалдан авах, гадаадын өндөр хөгжилтэй улс оронд өртөг өндөр эмчилгээ хийлгэх зэргээр хохирсоор байна.<br><br>Тиймээс үр ашиг, хүртээмж өндөртэй хувийн эрүүл мэндийн даатгалууд нэвтэрч өрсөлдөөн ихсэж байгаа өнөө цагт даатгал төлсөн иргэдэд үйлчлэх үйлчилгээг илүү сайжруулах, боловсронгуй болгох, даатгал төлснөөр авч болон үйлчилгээний талаарх мэдээллийг нийтэд түгээх, зөвлөмж гарган ажиллах шаардлагатай байна.<br><br>Хорт хавдрын эмчилгээг төрөөс 100 хувь даадаг болсон хэдий ч хавдрын эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ учир дутагдалтай байгаа тул ЭМДҮЗ-ийн 06 дугаартай "Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай" тогтоолын хэрэгжилтийг хангуулан ЭМД-ын мөнгөн хөрөнгийг даатгуулагчдад хэрхэн үр өгөөжтэй байдлаар ашиглах талаар санал санаачлагатай ажиллахаа илэрхийлэв.<br><br>**2/Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ:**<br><br>Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 07 тоот тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагад дүгнэлт өгөхөөр томилогдсоны дагуу нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийж, нэр дэвшигчээс мэдлэг шалгах сорил авч, ярилцлага зохион байгуулсаны үндсэн дээр хараат бус шинжээчийн дүгнэлт гаргалаа. |

Дээрх үнэлгээний үр дүнд үндэслэн нэр дэвшигч Т.Баясгалан нь ЭМДҮЗ-ийн гишүүнээр ажиллахад мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, ажлын туршлагын хувьд шаардлага хангасан, ашиг сонирхлын ямар нэгэн зөрчилгүй гэсэн дүгнэлтийг өгч байна.

**3/Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Т.Баясгаланг** хараат бус шинжээчийн дүгнэлт, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголоос гаргасан "Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохдоо Үндэсний зөвлөл нь санхүү, эрүүл мэндийн эдийн засгийн нарийн судалгаа, тооцоонд үндэслэн мэргэжлийн шийдвэр гаргадгийг харгалзан Үйлдвэрчний эвлэлд олон жил ажилласан, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл гэхээс илүү нийт даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрүүл мэндийн салбарын эдийн засгийн асуудлаар мэргэшсэн, мэдлэг, ур чадвартай хүнийг дэвшүүлэх" зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

**Сонсгол даргалагч:**

Ц.ИДЭРБАТ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 58 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:*** *Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

| | |
|---|---|
| **Нэр дэвшигчийн товч танилцуулга** | |
| 1 | **Эцэг/эхийн нэр:**Шагдар<br>**Нэр:** Зоригоо<br>**Хүйс:** Эрэгтэй<br>**Нэр дэвшүүлсэн байгууллага:** Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо |
| 2 | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**<br>Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаалыг бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн **ажил олгогчийг** төлөөлсөн гишүүн |

**Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэг Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

**1/**2022.03.22-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг баталсан. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч, УЗ-ийн дарга, “УБ-Сонгдо” эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дарга **Шагдарын Зоригоог** нэр дэвшүүлж, Байнгын хорооноос баталсан загварын дагуу материалыг ирүүлсэн болно.

**2/**2023.03.15-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” тогтоолыг батлаж, 2023.04.10-ны өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн **Цагаанхүүгийн Идэрбатыг** томилсон.

**3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:**

**-**Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу УИХ-ын цахим хуудаст байршуулсан

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, news.zindaa.mn, Ubn.mn, Times.mn, tovch.mn, zarig.mn, MGL радио, Монголын үндэсний олон нийтийн радио 23 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

-Мэдээллийн дагуу 4 оролцогч нэр дэвшигчээс асуулт асуухаар, 5 оролцогч үг, санал хэлэхээр бүртгүүлснийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар эрэмбэлэн бүртгэж, баталгаажуулсан.

-2023.04.04-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр **Лувсангийн Мөнх-Эрдэнийг** хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 саналаар томилсон.

-Шинжээч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125.10-т заасан эрхийн хүрээнд Байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч нэр дэвшигчидтэй 2023.04.06-ний өдөр Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд уулзалтыг зохион байгуулж ярилцлага авсан (нэг нэр дэвшигч эрүүл мэндийн шалтгааны улмаас цахимаар оролцсон) болно. Нэр дэвшигчдийн ирүүлсэн анкет, нэр дэвших үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлын мэдээлэл болон ярилцлагын дүнд үндэслэн 2023.04.07-ны өдөр Хараат бус шинжээчийн дүгнэлтийг Байнгын хороонд ирүүлснийг ажлын алба Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн болно.

**4/**Байнгын хорооны ажлын албанаас 2023.04.07-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.2-т заасны дагуу сонсголд оролцогчдод сонсголын дэгийг урьдчилан танилцуулсан.

**5/**2023.04.10-ны өдрийн 14:00 цагт Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс дээш гишүүд хүрэлцэн ирснээр ирц бүрдэж Нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат даргалан эхлүүлсэн. Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн, С.Чинзориг нарын гишүүд оролцсон.

**6/**Нэр дэвшигч Ш.Зоригоо нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ дүгнэлтээ танилцуулсан.

**7/**Танилцуулга, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, С.Ганбаатар нар асуулт асууж, хариулт авсан.

**Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа:** Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ тогтмол төлөөд тухайн жилдээ үйлчилгээ аваагүй иргэд төлсөн шимтгэлээ буцаан авах боломжтой эсэх талаар асуулт асуув.

**Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар:** Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг шамшигдуулсан албан тушаалтнуудад ямар хариуцлага хүлээлгэх болон сангийн хөрөнгийг хэрхэн хамгаалах, мөн өнгөрсөн 30 жилд ЭМД төлсөн иргэдээс

танай байгууллага дээр холбоотой хэдэн гомдол гаргасан, ирүүлсэн гомдлуудыг хэрхэн шийдвэрлэсэн судалгаа байгаа эсэх талаар, даатгуулагчдад тайлангаа хэрхэн гаргах талаар асуулт асуув.

**8/**Улсын Их Хурлын гишүүдийг асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан асуулт асуухаар бүртгүүлсэн оролцогч нар дараах дарааллын дагуу нэр дэвшигчээс асуулт асуусан.

**Р.Эрдэнэбат -** ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** - МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** - Иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн

**9/**Нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан үг хэлэхээр бүртгүүлсэн оролцогч нар саналаа хэлсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлэх санал гараагүй болно.

**Р.Эрдэнэбат** - ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** - МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** - Иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн
**Б.Булганчимэг -** Өвөрхангай, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, Эмнэлгийн удирдлагын зөвлөх

**10/**Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Цагаанхүүгийн Идэрбат хааж үг хэлсэн.

**Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ц.Идэрбат:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу анх удаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшигчдийг 3 үе шаттайгаар хэлэлцдэг тогтолцоо руу орж байна. Анх удаа хөндлөнгийн хараат бус шинжээч дүгнэлт хийж, нэр дэвшигч, төлөөллийн байгууллагууд оролцоод байр сууриа илэрхийллээ. Хөндлөнгийн шинжээч нэр дэвшигчдийн талаар өөрийнхөө дүгнэлтийг тал талаас нь хийж сонсголд танилцуулаад, нэр дэвшигч нар өөрсдийн байр сууриа илэрхийллээ. Байнгын хороо дүгнэлтээ хийгээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

**3 Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь**

Томилгооны сонсгол зохион байгуулах журмын 3.1-д зааснаар нэр дэвшигчийг санал болгох, нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, **сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан бичих** үе шат тус бүрийг Байнгын хороо хэрхэн зохион байгуулсан тухай болон сонсголыг Нийтийн сонсголын тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар нэгтгэн дүгнэж бичнэ. Дүгнэлтийнхээ гол үндэслэлийг товч бичнэ.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Нэр дэвшигчийн сонсголыг явуулах үе шат, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

| | |
|---|---|
| | дэгийн тухай хуулийн 123-126 дугаар зүйлийг баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2023.04.10-ны өдрийн 14:00 цагт зохион байгууллаа.<br><br>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2023.04.12-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргалаа. |
| **4** | **Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.** |
| | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогчийг төлөөлсөн гишүүнд Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч, УЗ-ийн дарга, "УБ-Сонгдо" эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дарга **Ш.Зоригоог** нэр дэвшүүлсэн бөгөөд:<br><br>**Хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл:**<br><br>1. ЭМДТухай хуулийг боловсронгуй болгох<br>2. ЭМДТухай хуулийн хэрэгжилтийг хангах<br>3. ЭМДТухай хуулийг хэрэгжүүлэх журам боловсронгуй болгох<br>4. ЭМДТухай хуулийн даатгалаар санхүүжих эмнэлгийн тусламжийн жагсаалтад мэргэжлийн тусламж үзүүлэх<br>5. ЭМДТухай хуулийг олон нийтэд таниулан сурталчилж ажиллахаа илэрхийлэв.<br><br>**2/Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ:**<br><br>Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 07 тоот тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд ажил олгогчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагад дүгнэлт өгөхөөр томилогдсоны дагуу нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийж, нэр дэвшигчээс мэдлэг шалгах сорил авч, ярилцлага зохион байгуулсаны үндсэн дээр хараат бус шинжээчийн дүгнэлт гаргалаа.<br><br>Дээрх үнэлгээний үр дүнд үндэслэн нэр дэвшигч Ш.Зоригоо нь ЭМДҮЗ-ийн гишүүнээр ажиллахад мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, ажлын туршлагын хувьд шаардлага хангасан, ашиг сонирхлын ямар нэгэн зөрчилгүй гэсэн дүгнэлтийг өгч байна.<br><br>**3/Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Ш.Зоригоог** эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг хувийн байгууллагад тодорхой албан тушаал хашдаг нь зарчмын хувьд тусламж, үйлчилгээг авдаг даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах төлөөлөл нь тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөл байж болохгүй, түүнчлэн хараат бус |

| | |
|---|---|
| | шинжээчийн дүгнэлт, ирүүлсэн материал, сонсголын үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд ажил олгогчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангаагүй гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэнгүй. |

**Сонсгол даргалагч:**

Ц.ИДЭРБАТ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 58 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:*** *Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

| | |
|---|---|
| **Нэр дэвшигчийн товч танилцуулга** | |
| 1 | **Эцэг/эхийн нэр:**Жамсран<br>**Нэр:** Гэрэлмаа<br>**Хүйс:** Эмэгтэй<br>**Нэр дэвшүүлсэн байгууллага:** Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо |
| 2 | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**<br>Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаалыг бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн **ажил олгогчийг** төлөөлсөн гишүүн |

**Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1.3$ дахь хэсэг Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

**1/**2022.03.22-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг баталсан. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооны УЗ-ийн гишүүн **Жамсрангийн Гэрэлмааг** нэр дэвшүүлж, Байнгын хорооноос баталсан загварын дагуу материалыг ирүүлсэн болно.

**2/**2023.03.15-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” тогтоолыг баталж, 2023.04.10-ны өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн **Цагаанхүүгийн Идэрбатыг** томилсон.

**3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:**

-Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу УИХ-ын цахим хуудаст байршуулсан

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, news.zindaa.mn, Ubn.mn, Times.mn, tovch.mn,

zarig.mn, MGL радио, Монголын үндэсний олон нийтийн радио 23 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

-Мэдээллийн дагуу 4 оролцогч нэр дэвшигчээс асуулт асуухаар, 5 оролцогч үг, санал хэлэхээр бүртгүүлснийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар эрэмбэлэн бүртгэж, баталгаажуулсан.

-2023.04.04-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр **Лувсангийн Мөнх-Эрдэнийг** хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 саналаар томилсон.

-Шинжээч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125.10-т заасан эрхийн хүрээнд Байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч нэр дэвшигчидтэй 2023.04.06-ний өдөр Төрийн ордны "Үндсэн хууль" танхимд уулзалтыг зохион байгуулж ярилцлага авсан (нэг нэр дэвшигч эрүүл мэндийн шалтгааны улмаас цахимаар оролцсон) болно. Нэр дэвшигчдийн ирүүлсэн анкет, нэр дэвших үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлын мэдээлэл болон ярилцлагын дүнд үндэслэн 2023.04.07-ны өдөр Хараат бус шинжээчийн дүгнэлтийг Байнгын хороонд ирүүлснийг ажлын алба Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн болно.

**4/**Байнгын хорооны ажлын албанаас 2023.04.07-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.2-т заасны дагуу сонсголд оролцогчдод сонсголын дэгийг урьдчилан танилцуулсан.

**5/**2023.04.10-ны өдрийн 14:00 цагт Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс дээш гишүүд хүрэлцэн ирснээр ирц бүрдэж Нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат даргалан эхлүүлсэн. Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн, С.Чинзориг нарын гишүүд оролцсон.

**6/**Нэр дэвшигч Ж.Гэрэлмаа нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ дүгнэлтээ танилцуулсан.

**7/**Танилцуулга, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, С.Ганбаатар нар асуулт асууж, хариулт авсан.

**Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа:** Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ тогтмол төлөөд тухайн жилдээ үйлчилгээ аваагүй иргэд төлсөн шимтгэлээ буцаан авах боломжтой эсэх болон Стратегийн худалдан авалтыг бэхжүүлэх тал дээр ямар зорилт тавьж ажиллах талаар асуулт асуув.

**Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар:** Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг шамшигдуулсан албан тушаалтнуудад ямар хариуцлага хүлээлгэх болон сангийн хөрөнгийг хэрхэн хамгаалах, мөн өнгөрсөн 30 жилд ЭМД төлсөн иргэдээс танай байгууллага дээр холбоотой хэдэн гомдол гаргасан, ирүүлсэн гомдлуудыг

хэрхэн шийдвэрлэсэн судалгаа байгаа эсэх талаар, даатгуулагчдад тайлангаа хэрхэн гаргах талаар асуулт асуув.

**8/**Улсын Их Хурлын гишүүдийг асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан асуулт асуухаар бүртгүүлсэн оролцогч нар дараах дараалын дагуу нэр дэвшигчээс асуулт асуусан.

**Р.Эрдэнэбат -** ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** - МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** - Иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн

**9/**Нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан үг хэлэхээр бүртгүүлсэн оролцогч нар саналаа хэлсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлэх санал гараагүй болно.

**Р.Эрдэнэбат** - ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн
**О.Жавзандулам** - МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн
**А.Батбаяр** - Иргэн, судлаач
**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн
**Б.Булганчимэг -** Өвөрхангай, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, Эмнэлгийн удирдлагын зөвлөх

**10/**Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Цагаанхүүгийн Идэрбат хааж үг хэлсэн.

**Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ц.Идэрбат:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу анх удаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшигчдийг 3 үе шаттайгаар хэлэлцдэг тогтолцоо руу орж байна. Анх удаа хөндлөнгийн хараат бус шинжээч дүгнэлт хийж, нэр дэвшигч, төлөөллийн байгууллагууд оролцоод байр сууриа илэрхийллээ. Хөндлөнгийн шинжээч нэр дэвшигчдийн талаар өөрийнхөө дүгнэлтийг тал талаас нь хийж сонсголд танилцуулаад, нэр дэвшигч нар өөрсдийн байр сууриа илэрхийллээ. Байнгын хороо дүгнэлтээ хийгээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

| | |
|---|---|
| 3 | **Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь**<br>Томилгооны сонсгол зохион байгуулах журмын 3.1-д зааснаар нэр дэвшигчийг санал болгох, нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, **сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан бичих** үе шат тус бүрийг Байнгын хороо хэрхэн зохион байгуулсан тухай болон сонсголыг Нийтийн сонсголын тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар нэгтгэн дүгнэж бичнэ. Дүгнэлтийнхээ гол үндэслэлийг товч бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Нэр дэвшигчийн сонсголыг явуулах үе шат, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-126 дугаар зүйлийг баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2023.04.10-ны өдрийн 14:00 цагт зохион байгууллаа. |

| | |
|---|---|
| | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2023.04.12-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргалаа. |
| 4 | **Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.** |
| | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогчийг төлөөлсөн гишүүнд Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооны УЗ-ийн гишүүн Ж.Гэрэлмааг дэвшүүлсэн бөгөөд:<br><br>**Нэр дэвшсэн үндэслэл:**<br>• Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14$^{1}$.2.3-т заасны дагуу Үндэсний зөвлөлд ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлсөн гурван хүн томилогддог. Монголын Ажил олгогч Эдийн Нэгдсэн холбоо нь 1990 онд байгуулагдсанаас хойш 21 аймагт салбартай, 41 мэргэжлийн холбоодтой, нийт 8100 гишүүн дэмжигчидтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хуулийн дагуу ажил олгогчийг төлөөлөх зөвлөлийн гишүүнээр Ж.Гэрэлмааг нэр дэвшүүлсэн байна.<br>• Олон улсад Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд ажил олгогч, даатгуулагч, төрийн төлөөллөөс гадна тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болох эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын эрх ашгийг төлөөлөх гишүүд багтдаг бөгөөд Монгол улсын Эрүүл мэндийн даатгалын хуулиар уг тал ЭМДҮЗ-ийн бүрэлдэхүүнд байхгүй хэдий ч Монголын ажил олгогч Эздийн Нэгдсэн холбооноос Сумын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн холбооны төлөөллийг 1) Нийт ажил олгогчийг эрх ашгийг төлөөлөх 2) Эрүүл мэндийн байгууллагуудын эрх ашгийг төлөөлүүлэхээр<br>• ЭМДҮЗ нь эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн даатгалын ирээдүйн хөгжил болон хүн амыг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалахад чухал нөлөө бүхий шийдвэрүүдийг гаргадаг тул эрүүл мэндийн бодлого, удирдлага, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр мэргэшиж буй туршлага, чадамжийг нь үнэлэн нэр дэвшүүлсэн байна.<br><br>**1/Нэр дэвшигч Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилогдвол** ЭМДҮЗ-ийн гишүүн нь бие даан үйл ажиллагаа явуулах, бие даан шийдвэр гаргах эрхгүй, гишүүдийн хамтын, дийлэнхи олонхийн шийдвэрээр шийдвэр гаргадаг. Миний бие ЭМДҮЗ-ийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1-т заасан ЭМДҮЗ-ийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дараах байр суурийг баримтлан ажиллах.<br>• Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг аль болох үр ашигтай, иргэн, даатгуулагчид ээлтэй байх зарцуулах байр суурьтайгаар ажиллах.<br>• Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрыг Стратегийн худалдан авагч болсон тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.<br>• Иргэн, даатгуулагчийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогыг дэмжиж ажиллах. |

| | |
|---|---|
| | ЭМДҮЗ-ийн шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилсан, ил тод байхад анхаарч ажиллахаа илэрхийлэв.<br><br>**2/Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ:**<br><br>Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 07 тоот тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд ажил олгогчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагад дүгнэлт өгөхөөр томилогдсоны дагуу нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийж, нэр дэвшигчээс мэдлэг шалгах сорил авч, ярилцлага зохион байгуулсаны үндсэн дээр хараат бус шинжээчийн дүгнэлт гаргалаа.<br><br>Дээрх үнэлгээний үр дүнд үндэслэн нэр дэвшигч Ж.Гэрэлмаа нь ЭМДҮЗ-ийн гишүүнээр ажиллахад мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, ажлын туршлагын хувьд шаардлага хангасан, ашиг сонирхлын ямар нэгэн зөрчилгүй гэсэн дүгнэлтийг өгч байна.<br><br>**3/Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Ж.Гэрэлмааг** хараат бус шинжээчийн дүгнэлт, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд дэмжлээ. |

**Сонсгол даргалагч:**

Ц.ИДЭРБАТ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 58 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

***Товч удирдамж:*** *Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.*

| **Нэр дэвшигчийн товч танилцуулга** | |
|---|---|
| 1 | **Эцэг/эхийн нэр:** Нэмэхээ<br>**Нэр:** Одонгуа<br>**Хүйс:** Эмэгтэй<br>**Нэр дэвшүүлсэн байгууллага:** Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим |
| 2 | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**<br>Нэр дэвшигч нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаалыг бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн **ажил олгогчийг** төлөөлсөн гишүүн |

**Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэг Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн Нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

**1/**2022.03.22-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг баталсан. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Бизнес академийн чиглүүлэгч багш, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн “Эрдмийн зөвлөл”-ийн гишүүн **Нэмэхээгийн Одонгуаг** нэр дэвшүүлж, Байнгын хорооноос баталсан загварын дагуу материалыг ирүүлсэн болно.

**2/**2023.03.15-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” тогтоолыг баталж, 2023.04.10-ны өдөр Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн **Цагаанхүүгийн Идэрбатыг** томилсон.

**3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд:**

-Нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу УИХ-ын цахим хуудаст байршуулсан

-Сонсголын тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, news.zindaa.mn, Ubn.mn, Times.mn, tovch.mn, zarig.mn, MGL радио, Монголын үндэсний олон нийтийн радио 23 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

-Мэдээллийн дагуу 4 оролцогч нэр дэвшигчээс асуулт асуухаар, 5 оролцогч үг, санал хэлэхээр бүртгүүлснийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар эрэмбэлэн бүртгэж, баталгаажуулсан.

-2023.04.04-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.8 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшсэн гишүүний мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр **Лувсангийн Мөнх-Эрдэнийг** хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3 саналаар томилсон.

-Шинжээч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125.10-т заасан эрхийн хүрээнд Байнгын хорооноос томилогдсон хараат бус шинжээч нэр дэвшигчидтэй 2023.04.06-ний өдөр Төрийн ордны "Үндсэн хууль" танхимд уулзалтыг зохион байгуулж ярилцлага авсан (нэг нэр дэвшигч эрүүл мэндийн шалтгааны улмаас цахимаар оролцсон) болно. Нэр дэвшигчдийн ирүүлсэн анкет, нэр дэвших үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлын мэдээлэл болон ярилцлагын дүнд үндэслэн 2023.04.07-ны өдөр Хараат бус шинжээчийн дүгнэлтийг Байнгын хороонд ирүүлснийг ажлын алба Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн болно.

**4/**Байнгын хорооны ажлын албанаас 2023.04.07-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.2-т заасны дагуу сонсголд оролцогчдод сонсголын дэгийг урьдчилан танилцуулсан.

**5/**2023.04.10-ны өдрийн 14:00 цагт Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс дээш гишүүд хүрэлцэн ирснээр ирц бүрдэж Нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат даргалан эхлүүлсэн. Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, С.Ганбаатар, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн, С.Чинзориг нарын гишүүд оролцсон.

**6/**Нэр дэвшигч Н.Одонгуа нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсны дараа Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ дүгнэлтээ танилцуулсан.

**7/**Танилцуулга, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар асуулт асууж, хариулт авсан.

**Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар:** Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг шамшигдуулсан албан тушаалтнуудад ямар хариуцлага хүлээлгэх болон сангийн хөрөнгийг хэрхэн хамгаалах, мөн өнгөрсөн 30 жилд ЭМД төлсөн иргэдээс танай байгууллага дээр холбоотой хэдэн гомдол гаргасан, ирүүлсэн гомдлуудыг хэрхэн шийдвэрлэсэн судалгаа байгаа эсэх талаар, даатгуулагчдад тайлангаа хэрхэн гаргах талаар асуулт асуув.

| | |
|---|---|
| | **8/**Улсын Их Хурлын гишүүдийг асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан асуулт асуухаар бүртгүүлсэн оролцогч нар дараах дарааллын дагуу нэр дэвшигчээс асуулт асуусан.<br><br>**Р.Эрдэнэбат -** ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн<br>**О.Жавзандулам** - МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн<br>**А.Батбаяр** - Иргэн, судлаач<br>**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн<br><br>**9/**Нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсны дараа урьдчилан үг хэлэхээр бүртгүүлсэн оролцогч нар саналаа хэлсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлэх санал гараагүй болно.<br><br>**Р.Эрдэнэбат** - ЭМД-ын хяналт ТББ-ын тэргүүн<br>**О.Жавзандулам** - МУИС-ийн ахмад багш, ажилтны нэгдсэн холбооны тэргүүн<br>**А.Батбаяр** - Иргэн, судлаач<br>**Г.Жаргалсайхан** - Монголын Сахарын өвчтэй иргэдийн нэгдэх “Жаргал” нийгэмлэгийн тэргүүн<br>**Б.Булганчимэг -** Өвөрхангай, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, Эмнэлгийн удирдлагын зөвлөх<br><br>**10/**Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Цагаанхүүгийн Идэрбат хааж үг хэлсэн.<br><br>**Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Ц.Идэрбат:** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу анх удаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд нэр дэвшигчдийг 3 үе шаттайгаар хэлэлцдэг тогтолцоо руу орж байна. Анх удаа хөндлөнгийн хараат бус шинжээч дүгнэлт хийж, нэр дэвшигч, төлөөллийн байгууллагууд оролцоод байр сууриа илэрхийллээ. Хөндлөнгийн шинжээч нэр дэвшигчдийн талаар өөрийнхөө дүгнэлтийг тал талаас нь хийж сонсголд танилцуулаад, нэр дэвшигч нар өөрсдийн байр сууриа илэрхийллээ. Байнгын хороо дүгнэлтээ хийгээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. |
| **3** | **Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь**<br>Томилгооны сонсгол зохион байгуулах журмын 3.1-д зааснаар нэр дэвшигчийг санал болгох, нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, **сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан бичих** үе шат тус бүрийг Байнгын хороо хэрхэн зохион байгуулсан тухай болон сонсголыг Нийтийн сонсголын тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдсан талаар нэгтгэн дүгнэж бичнэ. Дүгнэлтийнхээ гол үндэслэлийг товч бичнэ. |
| | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн $14^1$ дүгээр зүйлийн $14^1$.3 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Нэр дэвшигчийн сонсголыг явуулах үе шат, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-126 дугаар зүйлийг баримтлан Нэр дэвшигчийн сонсголыг 2023.04.10-ны өдрийн 14:00 цагт зохион байгууллаа. |

| | |
|---|---|
| | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор буюу 2023.04.12-ны өдөр хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргалаа. |
| **4** | **Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.** |
| | Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогчийг төлөөлсөн гишүүнд МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес академийн чиглүүлэгч багш, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн "Эрдмийн зөвлөл"-ийн гишүүн **Н.Одонгуаг** нэр дэвшүүлсэн бөгөөд:<br><br>**Нэр дэвшсэн үндэслэл:**<br>Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө өсөн нэмэгдэж, баталсан төсвийг бүрэн санхүүжүүлэн, даатгуулагч иргэдийн эрсдэлийг хуваалцах хөрөнгийн боломжтой нөөц хангалттай бүрдсэн гэж үзэж байна. Мөн Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тоо сүүлийн 3 жилд нэмэгдлээ. 2021 онд нийт 2200 орчим эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулж, давхардсан тоогоор 8.6 сая даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүллээ. Үүнд эрүүл мэндийн даатгалын сангаас 346.1 тэрбум төгрөгийг зарцуулсан. Гэлээ ч эрүүл мэндээ даатгуулсан иргэдэд чанартай ажил үйлчилгээ худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх талаар цаашдаа ихээхэн анхаарах шаардлагатай.<br><br>Цаашид ЭМДЕГ-н стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллахаа илэрхийлэв.<br><br>**1/Нэр дэвшигч Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилогдвол**<br><br>1. Хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ<br><br>1. Эрх зүйн хүрээнд ЭМДЕГ-ын үйл ажиллагааг үр дүнтэй болгоход ЭМД-ын сангийн удирдлагыг олон улсын жишгээр мэргэжлийн оролцогчдоор удирдуулах талд анхаарах цаг болжээ.<br>2. ЭМДҮЗ болон ЭМДЕГ-ын эрх хэмжээг тодорхой болгох, тайлагнах, хяналт тавих болон харьяалагдах үйл явцын ойлгомжгүй байдлыг арилгах шаардлагатай. Мөн хөндлөнгөөс тус агентлагийн үйл ажиллагаанд оролцох ялангуяа ЭМЯ-ны оролцоо, эрх хэмжээний заагийг тодорхойлж өгөх шаардлагатай.<br>3. Хуульд ЭМДЕГ нь когорт судалгаанд үндэслэн тусламж, үйлчилгээг хүргэх эрх зүйн үндсийг бий болгох, ингэхийн тулд нэг бол тус агентлаг бие даасан судалгаа, шинжилгээний нэгжтэй, бэлтгэгдсэн боловсон хүчинтэй, олон улсын туршлагыг судалж тусламж, үйлчилгээг хүргэх эсхүл НЭМҮТ-тэй хамтрах эрх зүйн хүрээг тодорхой болгож, когорт судалгааны захиалга өгөх, хамтран ажиллах, судалгааг хянах, санал зөвлөмж боловсруулах чадавхийг бүрдүүлэх шаардлагатай байна. |

4. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд ЭМД-ын сангийн удирдлага менежментийг зохион байгуулахад төрийн бусад байгууллагуудын хяналт, оролцоог хязгаарлах, бие даан шийдвэр гаргах эрх хэмжээг бүрдүүлэх шаардлагатай. Мөн хариуцлагыг төдий хэмээнд бие даан хүлээх хэрэгцээ байх тул мэргэшсэн боловсон хүчнийг шалгаруулж авдаг, ажлын үр дүнг гүйцэтгэлээр дүгнэх нөхцөлийг бүрдүүлэх, боловсонгуй болгох хэрэгтэй.

5. Эмнэлгийн зохион байгуулалт, төлөвлөлтийн албыг бий болгох нь эрх зүйн хүрээнд ЭМД-ын сангийн үр өгөөжийг нэмэгдүүлэхээр байна.

**2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

6. ЭМД-ын байгууллагын албан хаагчид ЭМД-ын сангаас олгох тусламж, үйлчилгээг хүлээн авагч буюу сонгон шалгаруулалт, тусламж үйлчилгээний харилцагчийг шалгаруулан, өөрсдөө эсхүл хамаарал бүхий этгээд (холбоотой байгууллагаараа дамжуулан)–ээр дамжуулан сонгон шалгаруулалтад хамрагдах, харилцагчаар оролцож төсвийн хуваарилалтаас хүртэж байгааг таслан зогсооход дараах арга хэмжээ авах. Үүнд:

**Дотоод хяналтын нэгж байгуулах.** Дотоод хяналтын одоогийн нэгж нь ЭМДЕГ-аас тусламж, үйлчилгээний зардалд төсвийн хуваарилалтад хамрагдсан харилцагчдыг хянах, шалгах эрх хэмжээтэй харин өөрийн албан хаагчдыг хянах, шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

**Эрсдэлийн удирдлагын бодлого**. Агентлаг нь эрсдлээ нэгж бүр, үйл ажиллагаа бүрээр тодорхойлох, Эрсдэлийн удирдлагын бодлого батлах, эрсдэлийг тогтмол үнэлэх, эрсдэлийн сан байгуулах, эрсдэлийг удирдах, хяналт тавих шаардлагатай. Уг эрсдэлд авлига, ашиг сонирхлын зөрчил, байгууллагад учирч болох эрсдэл, хүлээн зөвшөөрөх эрсдэл, даатгуулагчийн эрүүл мэндийн эрсдэл болон топ эрсдэлийг тодорхойлж, оновчтой удирдах, бууруулах чиглэлийн арга хэмжээг авах шаардлагатай байна. Мөн эрүүл мэндийн ирээдүйд учрах эрсдлийг оновчтой тооцож шимтгэлийн хураамжыг үндэслэлтэйгээр нэмэх, эсвэл бууруулах арга хэмжээг авах шаардлагатай байна. Ялангуяа харилцагчийн эрсдэл, үйл ажиллагааны үр дүнд үзүүлэх эрсдэлийг зайлшгүй тодорхойлсон байх үүрэгтэй.

**3. Хүний нөөц, санхүүжилт ба ил тод байдал бүрдүүлэх арга хэмжээ**

7. Эрүүл мэндийн эдийн засаг, эрсдлийн үнэлгээ хийх чадамж бүхий судалгааны бие даасан нэгж, мэргэжилтэнтэй болох, ЭМД-ын санхүүжилтийг судалгаа, шинжилгээнд төлөвлөж, зарцуулах, үр дүнг тооцоолох шаардлагатай. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сургалт мэдээлэллийн үйл ажиллагааны зардалд тусгах төсвийн хэмжээг байгууллагын жилийн төсвийн 5 хувьд хүргэх.

8. Судалгааны арга зүйлд когорт судалгаа хийх арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийг энэ чиглэлээр чадавхижуулах ба төлөвлөлтийг когорт судалгаанд суурилж тодорхойлж, төлөвлөх шаардлагатай байна.

9. Хүний нөөцийг эрүүл мэндийн эдийн засаг, эрсдлийн үнэлгээ сангийн удирдлагаар мэргэшсэн боловсон хүчнээр өргөжүүлэх,

10. Жилийн тайланд агентлагийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх хэсэг нэмэх, хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг мэдээлэх. Мөн байгууллагын ажилтан, албан хаагч бусад ажилтны зөрчил, мэдээллийг гаргах шүгэл үлээх механизмыг дотооддоо бүрэн бүрдүүлэх нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс

ангид байх, таслан зогсоох, бууруулахад дэмжлэг үзүүлнэ. Уг сувгаар ирсэн мэдээллийг хөндлөнгөөс хянах, шалгах чадавхи бүрдүүлэх нь чухал.

11. Сургалтын стратеги, төлөвлөгөөг боловсруулж, зайлшгүй хамрагдах сургалтын жагсаалт гаргаж, жишиг стандартад нийцүүлэн жагсаалтад заасан сургалтад албан хаагчдыг заавал хамруулж хэвшүүлэх шаардлагатай. тогтмол сургалт зохион байгуулах хэрэгцээтэй. Мэргэжлийн ур чадвар олгох сургалт, ёс зүйн сургалт, бусад мэргэшүүлэх сургалт гэсэн ялгамжийг ойлгох, Хүний нөөцийн бодлогын нэг томоохон арга хэмжээ болгох шаардлагатай. Удирдлагын академид зөвхөн сургаж байгааг мэргэжлийн ур чадвар олгох сургалт гэж ойлгох нь өрөөсгөл бөгөөд шаардлага хангах эсэхийг үнэлсэн үнэлгээгүй явж ирсэн нь учир дутагдалтай ба бусад, ялангуяа төрийн бус байгууллага, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай нягт хамтран ажиллах, мэрдэг, туршлага солилцох, сургалт авах зайлшгүй шаардлага байна.

12. Ёс зүйн дүрэмд шаардлагатай, олон улсын жишигт нийцсэн өөрчлөлтийг тусгаж батлах, Ёс зүйн хорооны үйл ажиллагааг нэмэгдүүлэн сайжруулах, байгууллагын албан хаагчид болон харилцагч байгууллагын ажилтантай холбоотой гаргасан зөрчлийг хэлэлцдэг, бүртгэлжүүлдэг, хариуцлага тооцдог болох, хариуцлага тооцох байдлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай.

## 4. Худалдан авалт ба Харилцагчийн магадлан баталгаажуулах арга хэмжээ

13. Худалдан авалтын ил тод байдлыг цахим хуудсанд хангаж, тендэр зохион байгуулалтыг өөрийн цахим хуудсаар давхар мэдээлэх, шалгуур үзүүлэлт, шаргуур хангасан байдал, сонгогдсон харилцагчдын нэр, улсын бүртгэлийн дугаар, байгууллагын хаяг, удирдлагын бүтэн нэр, хаяг, утас, холбоотой этгээд болон улс төрд нөлөө бүхий этгээдийг хянасан баримт, техник, хүний нөөц ба санхүүгийн чадавхийн үнэлгээг олон нийтэд ил тод болгох шаардлагатай.

14. Агентлагийн даргын тушаалаар нийслэл, орон нутгийн хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд иргэдийн төлөөллийг оролцуулах, ажлын хэсгийн үйл ажиллагааны мэдээллийг нээлттэй болгож, цахим хуудсаараа мэдээлэх шаардлагатай байна.

15. Эмнэлэгийн магадлал итгэмжлэл, сонгон шалгаруулалтад багтсан байгууллагуудад сонгон шалгаруулалтаас өмнө, явцын дунд болон үр дүнгийн хаалтын үед тавигдах шаардлага, хяналт, хариуцлагыг сайжруулах, харилцлага тооцохдоо мөнгөн дүнгээр торгууль ногдуулах нөхцөлийг бүрдүүлсэх шаардлагатай.

16. Харилцагчийн “хар жагсаалт” гаргаж, уг жагсаалтад орсон байгууллага, иргэнийг худалдан авалт, сонгон шалгаруулалтад орохыг тодорхой хугацаанд таслан зогсоох шаардлагатай.

17. Харилцагч, сонгон шалгаруулалтад хамрагдсан байгууллагын хяналтыг цахимаар хийх нөхцөлийг бүрдүүлж, албан хаагчдын биечлэн очиж хяналт тавих нэрээр авлига, ашиг сонирхлын зөрчлийг бий болгох байдлыг арилгах.

## 5. Хамтын ажиллагаа

18. Хамтран ажиллах төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг болон холбоо, олон улсын байгууллагын салбар төлөөлөгчийн газрын тоо ба чанарыг нэмэгдүүлэх, хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцож, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх хэрэгцээтэй байна. Хамтран ажиллах төрийн бус

байгууллагад тавигдах шалгуурыг тодорхойлж, мөн адил магадлан баталгаажуулалт хийдэг байх, эрсдэлийн үнэлгээ хийх, харилцагчийг таньж мэдэх шаардлагатай.

**2/Хараат бус шинжээч Л.Мөнх-Эрдэнэ:**

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 07 тоот тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд ажил олгогчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагад дүгнэлт өгөхөөр томилогдсоны дагуу нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийж, нэр дэвшигчээс мэдлэг шалгах сорил авч, ярилцлага зохион байгуулсаны үндсэн дээр хараат бус шинжээчийн дүгнэлт гаргалаа.

Дээрх үнэлгээний үр дүнд үндэслэн нэр дэвшигч Н.Одонгуа нь ЭМДҮЗ-ийн гишүүнээр ажиллахад мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, ажлын туршлагын хувьд шаардлага хангасан, ашиг сонирхлын ямар нэгэн зөрчилгүй гэсэн дүгнэлтийг өгч байна.

**3/Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Н.Одонгуаг** хараат бус шинжээчийн дүгнэлт, ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд дэмжлээ.

**Сонсгол даргалагч:**

Ц.ИДЭРБАТ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН